| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Инновацын зөвлөл нь тус онд шинээр нэвтрүүлсэн эмчилгээ оношилгооны талаарх судалгаа шинжилгээ мэдээ мэдээллийг 100% баримтжуулан мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна | |
| 5.4 | Гэмтлийн яаралтай тусламжийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах хөтөлбөрийг боловсруулж батлуулна. | - | Батлагдсан сургалтын хөтөлбөр | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах гэрээг ЭМХТөвтэй байгуулж дараах 2 чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн батлуулсан. Энэ хүрээнд “ӨВДӨГНИЙ ҮЕНИЙ ДУРАНГИЙН МЭС ЗАСАЛ” чиглэлээр 2 эмч, “ӨВДӨГ, ТҮНХНИЙ ҮЕ СОЛИХ, ӨВДӨГ, ТҮНХНИЙ ҮЕ БҮТЭЭХ МЭС | Сургалтын хөтөлбөрийг боловсруулж Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр батлуулан сургалт зохион байгуулах эрх авсан байна. | Эрүүл мэндийн хөгжлийн төвд “Гэмтлийн яаралтай тусламж” богино хугацааны дээшлүүлэх сургалтын эрх авахаар материал хүргүүлэн хөтөлбөр засах шатандаа ажиллаж байна. | 50% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ЗАСАЛ" чиглэлээр 1 эмч төгссөн байна. | | | |
| ***ЗОРИЛТ 6: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ,САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАНА.*** | | | | | | | |
| 6.1 | Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлж өр авлагагүй ажиллана. | - | Өр, авлагын хэмжээ | Төсвийн гүйцэтгэл 63,7 тэрбум төгрөгийн төсөвтэй, 60,1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь нийт зардлын 52,8%-ийг цалингийн зардал эзэлж байна. Засгийн газрын 2024 оны 03 сарын 28-ний 128 дугаар тогтоолын дагуу нийт ажиллагсдын цалин 5-25 хувь нэмэгдсэн. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн авлага 19,4 тэрбум төгрөг, үүний 12,9 тэрбум нь урд жилүүдийн авлага байна. ЭМД-ын | Өр авлагагүй ажиллана. | Төсвийн орлого 11 сарын байдлаар 58.6 тэрбум төгрөгийн төсөвтэй, 56,6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, орлогын төлөвлөгөөний биелэлт 96,5 хувийн биелэлттэй. Төсвийн зарлага 55,9 тэрбум төгрөгийн төсөвтэй, 56,4 тэрбум төгрөгийн зарцуулалттай байна. Зарлагын төлөвлөгөөний биелэлт 100,9 хувьтай байна. Оны эхний авлагын үлдэгдэл 19,4 тэрбум, өглөгийн үлдэгдэл 15,9 тэрбум төгрөг, тайлант хугацааны эцэст өглөг 15,2 тэрбум төгрөг, авлага 14,1 тэрбум төгрөг. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт хугацаандаа бүрэн хийгдэхгүй байгаагаас бэлтгэн нийлүүлэгчдэд өртэй байна. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | санхүүжилт дутуу хийгдэж байгаагаас төсөвт хэмжээнд зардлыг зарцуулж чадахгүй, бэлтгэн нийлүүлэгчид өртэй гарч байна. | | | |
| 6.2 | Өдрийн эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | - | Тусламж үйлчилгээ үзүүлсэн тоо | 2024 онд нийт 251 өдрийн эмчилгээний түүх нээж сэргээн засахын тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. 4 үйлчлүүлэгчдэд өдрийн мэс заслын эмчилгээ хийгдсэн. | Сэргээн засахын өдрийн өдрийн эмчилгээнд 400-с доошгүй, өдрийн мэс заслын эмчилгээнд 10-с доошгүй үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлж хүртээмжийг нэмэгдүүлсэн байна | Төв болон салбар эмнэлгийн сэргээн засах өдрийн эмчилгээнд нийт 240 иргэнд тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. | 60% |
| 6.3 | *БСТ 5.1.5*<br>Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй тусламж үйлчилгээг даатгалд хамруулахад шаардлагатай саналыг хүргүүлнэ. | - | Тусламж үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан оношийн хамааралтай бүлгийн тоо. | Мөр, тохой, шагайн хиймэл үе солих мэс засал, суулгасан хиймэл үений суулгацыг дахин солих гэх мэт 41 мэс заслын өртөг зардлыг тооцож ЭМДҮЗ-ийн 08-р тогтоолын оношны хамааралтай бүлгийн жагсаалтад нэмж оруулах | Тусламж үйлчилгээний төрөл, хүртээмж, оношийн хамааралтай бүлгийн тоо нэмэгдсэн байна. | 2025 оны 2 сарын 14-нд тогтоолд тусгагдаагүй 23 хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний өртөг зардлыг тооцож ЭМДҮЗ-ийн 04-р тогтоолын оношны хамааралтай бүлгийн жагсаалтад нэмж оруулах саналыг ЭМДЕГ-т хүргүүлэн ажиллаа.<br>2025.11.04 нд Үений тарилга эмчилгээг өдрийн эмчилгээгээр нэхэмжлэх | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | саналыг ЭМДЕГ-т хүргүүлсэн байна. ЭМДЕГазарт Телемедицин болон түргэн тусламжаар нэмэлт гэрээ байгуулсан байна. | | саналыг ЭМДЕГ-ын Бодлого Төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажиллалаа. | |
| 6.4 | Үндсэн болон төсөвт хөрөнгийн төлөвлөлт, ашиглалт, зарцуулалтыг сайжруулан бүртгэл мэдээллийн цахим санг байгуулна. | 40.0 | Шинээр нэвтрүүлсэн программ | Санхүү бүртгэлийн албанд ашиглагдаж буй программ нь онлайнаар ажиллах боломжгүй байдаг. | Онлайн орчинд ажилладаг санхүүгийн программыг нэвтрүүлэн төвийн хэмжээнд ашиглаж эхэлсэн байна. | ТӨБЗГ-ын цахим программд 2024 оны үндсэн хөрөнгийн хөдлөлийн тайлан болон санхүүгийн тайланг шивж, 2025 оны 04 сарын 01-ны өдөр илгээсэн. Санхүүгийн тооцоолохын Acolous программын шинэчилсэн хувилбарыг судалж, 7 сарын 1-нээс туршилтын журмаар касс, харилцах бараа материалаас нэвтрүүлж эхэлсэн боловч экспорт, импорт хийхэд алдаатай татагдаад байсан тул хөгжүүлэлт, сайжруулалт бүрэн хийгдсэний үндсэн хөрөнгийн бүртгэлийг оруулна. | 50% |
| ***ЗОРИЛТ 7: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ОСОЛ ГЭМТЛИЙН ҮЕИЙН ТАНДАЛТ СУДАЛГААГ ӨРГӨЖҮҮЛНЭ.*** | | | | | | | |
| 7.1 | *(Алсын хараа 2050 2.2.31)* | - | Хяналт үнэлгээний тоо | Осол гэмтлийн тандалтын цахим санд хяналт хийж, | Нийслэлийн эмнэлгүүдийн тандалтын мэдээлэл | Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудад 7 удаагийн цахим болон танхимын сургалт | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Осол гэмтлийн тандалтын тогтолцоог өргөжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн ЭМГазар болон осол гэмтлийн яаралтай тусламж үзүүлж буй зарим эмнэлгүүдийн тандалтын мэдээлэл бүрдүүлэлтэд хяналт, үнэлгээ хийж сургалт зохион байгуулна. | | Зохион байгуулсан сургалтын тоо | харилцагч эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай мэдээлэл, мэргэжил аргазүйгээр хангаж ажиллаж байна. | бүрдүүлэлтэд 2 удаа хяналт, үнэлгээ хийж, сургалт зохион байгуулсан байна. | зохион байгуулсан. Осол гэмтлийн тандалтын мэдээллийн бүртгэл, чанар, үнэн зөв, бүрэн байдлыг үнэлж анхан шатны эх сурвалжтай тулган шалгах, мэдээлэл дамжуулах үйл явц болон мэдээлэл хариуцсан ажилтнуудын мэдлэг, арга зүй, хандлагыг тодорхойлох зорилгоор ТТАХНЭ, БГДЭМТ, ЦТЭ, СХДЭМТ, ЭХЭМҮТ, ШШЕГ зэрэг 6 байгууллагад хяналт, үнэлгээний ажлыг зохион байгуулсан ба хяналт үнэлгээний тайлан, зөвлөмжийг нэгтгэн холбогдох байгууллагуудад илгээсэн. . | 100% |
| 7.2 | Сургуулийн орчин дахь суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ зохион байгуулна. (осол гэмтэл, хүчирхийлэл) | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 2024 онд 6 сургууль, 3 цэцэрлэгт хүүхдийг осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийг хийсэн. | Осол гэмтэлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, эцэг, эх, асран хамгаалагч, багш ажилтнуудад мэдлэг олгох сургалтыг 10 сургууль, 10 цэцэрлэгт тус тус зохион байгуулна. | Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих зорилгоор нийслэлийн ерөнхий боловсролын 9 сургууль , 4 цэцэрлэгийн нийт 1017 сурагч, багш, ажилтан албан хаагч,хүүхдүүдэд дараах сэдвээр сургалт, сурталчилгаа,нөлөөллийн ажлыг зохион байгууллаа. “Сургуулийн орчин дахь | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдал" ”Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх" "Хүүхдийг ахуйн хүрээний осол гэмтэлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх нь "Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх" "Хүүхдэд аюулгүй ээлтэй орчин бүрдүүлэх" | |
| 7.3 | "Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе аян-"ны хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | "Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе аяны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд иргэд олон нийтэд 1 удаа өдөрлөг зохион байгуулсан. | Төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна. | **"Аюулгүй байдлын төлөө үгээ хэлье"-** осол гэмтлээс сэргийлэх өдөрлөгийг 2025 оны 6-р сарын 01 нд 07 цагаас 18 цаг хүртэл Жанжин Д.Сүхбаатарын талбайд ГССҮТ-ийн нийт 9 эмч, эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр тусламж үйлчилгээг хүргэж ажилласан. Үүнд эмчийн үзлэг болон сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 450 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүллээ. | 100% |
| 7.4 | Сургуулийн өмнөх болон сургуулийн | - | Зөвлөмж мэдээлэл, | Олон улсын сургуулийн 40 | БГД-ийн төрийн өмчит 3 сургуулийн 500 хүүхдэд | ГССҮТ-ийн захирлын 2025 оны 04.07-ны өдрийн А/72 тоот | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | насны хүүхдүүдийг осол гэмтлээс сэргийлэх, эрүүл мэндийн цогц боловсрол олгох, (visit tour-аар цэцэрлэг, сургуулийн хүүхдүүд хичээлээс гадуурх ажлын хүрээнд зочилж ирдэг) практик орчинд онол, дадлагатай хослуулсан зан үйлийн загвар сургалтын жишиг төвийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. (насан туршийн боловсрол олгох) | | сургалт, сурталчилгааны тоо | (хувийн) хүүхдийг төвийн практик үйл ажиллагаатай танилцуулж осол гэмтлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж байсан. | осол гэмтлээс урьдчилан сэргийлэх амьдралын зөв дадал хэвшилд сургах практик орчны сургалтыг зохион байгуулж мэдлэг ойлголтыг дээшлүүлнэ. | тушаалын дагуу“Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сурагчдад осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшүүлэх практик сургалт” ийг 2025 онд хавар, намрын 2-р ээлжээр НЕБ-ын 13-р сургууль болон Монгени, 77, 54-р сургуулийн дунд ангийн 500 сурагчдад осол гэмтлийн шалтгаант өвчлөлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ээлтэй аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр мэдээлэл сургалт онолын мэдлэг болон осол гэмтлийн үеийн анхны тусламжийн практик сургалтыг зохион байгуулж осол гэмтлийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлж ажиллаа. | 100% |
| 7.5 | *МУЗГҮАХ 2.1.1.24*. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, тэгш, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх | 40.0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, | Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд эмнэлгийн тусламж,үйлчилгээний талаар мэдээлэл хүргэх | Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байна. | ГССҮТөвийн захирлын А/129 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, тэдний онцлог хэрэгцээ шаардлагыг хангасан орчин нөхцөлийг бүрдүүлэх” | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангана. | | | зорилгоор “**Шидэт гар**” дохионы хэлний сургалтын төвтэй хамтран 56 сувилагч, тусгай мэргэжилтэн, цахим бүртгэгч, хөтөч нарт зориулсан дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулсан. | | чиглэлээр ажлын хэсгийг байгуулж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. | |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

Эрүүл мэндийн сайд ........................................ /Ж.ЧИНБҮРЭН/
/албан тушаал/ /гарын үсэг /

Тэмдэг

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

............................
/огноо/

ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАСАН:

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал .................................. /Э.ГАЛБАДРАХ/
/албан тушаал / /гарын үсэг/

Тэмдэг

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

............................
/огноо/

## ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХАВСРАЛТ

*Хавсралт 1.2*

### БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ГЭМТЭЛ СОГОГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ХҮРЭЭНД ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ.

Баянхонгор аймагт “Гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төвлөрлийг сааруулах төсөл”-г 1 жилийн хугацаатай хэрэгжүүлсэн.Төслийн хүрээнд Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмч нарын баг тухайн орон нутгийн иргэдэд гэмтэл согогийн яаралтай болон төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ болон мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан. Түүнчлэн Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан “Гэмтлийн үеийн яаралтай тусламж” сэдэвт онол, дадлага хосолсон сургалтаар тус аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Боловсролын байгууллагын 47 ажилтан, албан хаагч болон Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, сум, Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 207 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэдээлэл, зөвлөмж хүргэжээ.














<table>
<tr>
<td>Хавсралт 1.6</td>
<td>Тайлант хугацаанд төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж байсан 21  цаасан маягтаас 8 маягтыг цахим программд нэвтрүүлж өмнөх оны цаасаар хөтлөгддөг маягтыг   38%-иар бууруулсан үзүүлэлттэй байна.<br>



</td>
</tr>
<tr>
<td>Хавсралт 1.7</td>
<td>Эрүүл амьдралын хэв маягийг бий болгох, байгууллагын эмч, эмнэлгийн  ажилтнууд болон иргэд олон нийтэд чиглэсэн эрсдэлт зан үйлийг бууруулах осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр байгууллага хамт олонд чиглэсэн сургалт-14 удаа, Иргэд олон нийтэд чиглэсэн аян өдөрлөгийг-10 удаа зохион байгуулсан байна.<br>










</td>
</tr>
</table>

*Хавсралт 2.3*

1. ХҮНД ХЭЛБЭРИЙН ДУНД ЧӨМӨГНИЙ БУЛУУНЫ ДУТУУ ХӨГЖЛИЙГ ДУРАНГИЙН МЭС ЗАСЛЫН АРГААР СЭРГЭЭХ МЭС ЗАСЛЫГ ШИНЭЭР НЭВТРҮҮЛЛЭЭ.

ГССҮТөвийн Спортын гэмтлийн тасаг нь Arthroscopic sulcus deepening TROCHLEOPLASTY эмчлэх мэс заслыг 10 эмчлүүлэгчид хийж эмнэлзүйд нэвтрүүлэв.




**Dejour type-D**



**Мэс заслын дараах С**



**Мэс заслын өмнө**



**Мэс заслын дараа**

2. ҮЕНИЙ МӨГӨӨРСНИЙ ГЭМТЛИЙГ БИО-МЕМРАН АШИГЛАЖ СЭРГЭЭХ МЭС ЗАСЛЫГ ШИНЭЭР НЭВТРҮҮЛЛЭЭ.

ГССҮТөвийн Спортын гэмтлийн тасаг нь Үений мөгөөрсний гэмтлийг AMIC (Autologous Matrix-Induced Chondrogenesis) ашиглаж эмчлэх мэс заслыг 3 дугаар улирлаас хийж эхэлсэн.









3. ЯСНЫ ДУТМАГШЛЫГ НӨХӨЖ ГАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭЖ ӨВЧТӨНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛЖ ЧӨМӨГТ ЯСНЫ ДУТМАГШЛЫГ НӨХӨХ МЭС ЗАСЛЫГ ШИНЭЭР НЭВТРҮҮЛЛЭЭ.

ГССҮТөвийн Гар сарвууны мэс заслын тасгийн баг хүнд бэртлийн улмаас атгаалын чөмөгт ясны дунд хэсэгтээ 14.7 см дутмагшил үүссэн эргэн төлжих болон бороолох боломжгүй бяцарсан ил хугарлыг ясны дутмагшлыг нөхөж гарын үйл ажиллагааг сэргээж өвчтөний амьдармуй чанарыг сайжруулж чөмөгт ясны дутмагшлыг нөхөх мэс заслыг амжилттай хийж нэвтрүүлсэн.








4. АТГААЛ ЯСНЫ ЧӨМӨГТ ХЭСГИЙН ЯСНЫ ДУТМАГШЛЫГ НӨХӨХ МЭС ЗАСЛЫГ ШИНЭЭР НЭВТРҮҮЛЛЭЭ.

ГССҮТөвийн Гар сарвууны мэс заслын тасгийн баг атгаал ясны чөмөгт хэсгийн ясны дутмагшлыг нөхөж гарын үйл ажиллагааг сэргээж өвчтөний амьдралын чанарыг сайжрууллаа.









5. ХҮҮХДИЙН ӨВДӨГНИЙ ҮЕНИЙ УРД ЧАГТАН ХОЛБООСНЫ ГЭМТЛИЙГ ГАДНА ЧАНГАЛАГЧ ХАЛЬСААР ДУРАНГИЙН АРГААР СЭРГЭЭХ МЭС ЗАСЛЫГ НЭВТРҮҮЛЛЭЭ.

ГССҮТөвийн Хүүхдийн мэс заслын тасгийн баг Хүүхдийн өвдөгний үений урд чагтан холбоосны гэмтлийг гадна чангалагч хальсаар дурангийн аргаар сэргээх мэс заслыг хийсэн.










6. ХҮҮХДИЙН ТӨРӨЛХИЙН ДИСКОЙД МЕНИСКУС СОГОГИЙГ ДУРАНГИЙН АРГААР ЭМЧЛЭХ МЭС ЗАСЛЫГ НЭВТРҮҮЛЛЭЭ.

ГССҮТөвийн Хүүхдийн мэс заслын тасгийн баг хүүхдийн төрөлхийн дискойд мениснус согогийг дурангийн аргаар эмчлэх мэс заслыг хийж байна.








<table>
<tr>
<td>Хавсралт 2.4</td>
<td>

ЯСНЫ ХОРТОЙ ХАВДРЫН ҮЕИЙН ХАВДРЫГ БҮРЭН АВЧ ЯС ОРЛУУЛАХ ХИЙМЭЛ ҮЕЭР СОЛИХ МЭС ЗАСЛЫГ 2-ООС ДООШГҮЙ ХИЙЖ ХҮРТЭЭМЖИЙН НЭМЭГДҮҮЛЛЭЭ.

Ясны эмгэгийн мэс заслын тасаг нь 13 настай эмэгтэй  ясны хавдартай үйлчлүүлэгчид дунд чөмгний доод булууны хавдар, 19 настай эрэгтэйн дунд чөмгний доод булууны хавдрыг тус тус  авч Mutars брэндийн мега протез суулгах 2 мэс засаг хийж хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.






</td>
</tr>
<tr>
<td>Хавсралт 2.5</td>
<td>

ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ  ОРЧИН ҮЕИЙН ДЭВШИЛТЭТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТООГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ.

Төвийн хэмжээнд тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийн 9 төрлийн 18 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авсан.


“SIEMENS HEALTHINEERS”<br>MRI шинжилгээний аппарат



Нейромонитор


Тархины цахилгаан идэвхжил хэмжигч монитор

</td>
</tr>
</table>

| | |
|---|---|
| | <br>Тасралтгүй бөөр орлуулах аппарат<br><br>Мэс заслын ор-4<br><br>Мөчдийн мэс заслын чангалуур аппарат-4<br><br>Carl Zeiss Pentero 800 Микроскоп<br><br>Васуум мотор / О2 үйлдвэр/<br><br><br>Мэдрэлийн мэс заслын өндөр хурдны дрилл |
| *Хавсралт 2.6* | СУВИЛАГЧ НАРЫН “МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР”-Т ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛЭЭ.<br>Гэмтэл согог судлалын үндэсний төв нь Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/451 дүгээр тушаалаар батлагдсан “Сувилагч, эх баригч мэргэжилтний цогц чадамж”-д суурилан сувилагч мэргэжилтний хөгжил, ур чадварын түвшинг тодорхойлох жишиг аргачлалын дагуу үнэлэх үйл ажиллагааг зохион байгууллаа.Тус үнэлгээнд онол болон дадлагын дөрвөн өртөөгөөр төв болон салбар эмнэлгийн нийт 265 сувилагч хамрагдахаас 239 буюу 86,2%-н ирцтэй хамрагдсан. Нийт үнэлгээнд хамрагдсан сувилагч нарын дундаж үнэлгээ 69,3%-тай байна. Энэхүү үнэлгээний гол зорилго нь, нэг талаас сувилагч мэргэжилтэн нь өөрийн ур чадварын түвшинг тодорхойлох, ажлын байран дээрээ тасралтгүй суралцах, өөрийгөө үнэлэх, хөгжүүлэх бол, нөгөө талаас эрүүл мэндийн байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлж хамтран ажилласнаар сувилахуйн салбарын хөгжилд ахиц дэвшил гарах төдийгүй эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, нийгэмд сувилагч мэргэжилтний үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн юм. Үнэлгээний үр дүнд тулгуурлан цаашид сувилагч мэргэжилтний ажлын байран дээрх нэгдсэн болон |

| | |
|---|---|
| | бүлгийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан байгууллагын үйл ажиллагаанд тусгаж ажиллана.Сувилагч нарын ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд өндөр оноо авсан сувилагчдыг БНХАУ-д 5 хоногийн сургалтад үе шаттай хамруулсан.     |
| Хавсралт 3.2 | Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс улс орон даяар зарлан мэдээллийн дохиог гурван удаа дамжуулсан бөгөөд энэ үеэр төв эмнэлгийн 105, салбар эмнэлгийн 68 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ойр байгаа аюулгүйн цугларах талбайд гарч, дадлага сургуульд оролцсон. Төвийн захирлын А/143 тоот тушаалаар Байгууллагын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг шинэчлэн томилж, бүрэлдэхүүн ажил үүргийн хуваарийг тус тушаалын хавсралтаар баталсан.<br>Мөн байгууллагын хэмжээнд “Галын аюулгүй байдал”-г хангах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллаа.     |
| Хавсралт 3.3 | ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭХ 1 ТАСГИЙН КОРПУСЫГ БҮРЭН ЗАСВАРЛАЛАА.<br>ГССҮТөв нь 2025 онд Амбулаторийн хэвтэн эмчлүүлэх тасгийг үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд тохируулан иж бүрэн засвар хийж, ашиглалтад оруууллаа. Тухайлбал тасгийн өрөө бүрд гүйдэг хаалга, кондейшн, интернэт сүлжээ, 180 градус эргэдэг орны гэрэл, цахилгаан залгуур, дуут дохиолол бүхий утаа мэдрэгчийг суурилуулж, дуу чимээнээс тусгаарлах эмнэлгийн зориулалттай эко хавтангаар ханыг засварлан тохижуулжээ.Мөн цэвэр болон бохир усны шугамыг шинэчилж, үйлчилгээний ажилтнуудын ажлыг |

Сувилагчийн хөгжил, ур чадварын түвшин сайжруулах сургалтын төлөвлөгөө

Зорилго: Сувилагч мэргэжилтний хөгжил ур чадвар түвшинг тасралтгүй үнэлж, үр дүнг тооцон мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулах

| ДД | Сургалт, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга | Хүрэх үр дүн | Хугацаа/улирал | | | | Хариуцах мэргэжилтэн | Хяналт хийх мэргэжилтэн | Хамрах хүрээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I | II | III | IV | | | |
| 1.Сэтгэн бодох шийдвэр гаргах ур чадварт суралцах | | | | | | | | | | |
| 1.1 | Эмнэлзүйн тохиолдолд тулгуурласан шийдвэр гаргах сургалт | Тохиолдол болон бүлгийн хэлэлцүүлэг хийх | Сувилагч эмнэлзүйн асуудалд дүн шинжилгээ хийх, зөв шийдвэр гаргах чадвартай болно | | | | /v/ | Эмнэлзүйн сургагч багш нар | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 1.2 | Асуудал шийдвэрлэх ур чадварын дадлага сургалт | Тохиолдол кейс дээр суурилсан дасгал ажил | Сувилагч өөрийн тулгарах дээр тулгуурлан асуудлыг дүгнэх шийдвэр гаргадаг болно | | | | /v/ | Эмнэлзүйн сургагч багш нар | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 1.3 | Стрессийн үед шийдвэр гаргах дадлага сургалт | Тохиолдол кейс дээр суурилсан дасгал ажил | Сувилагч стрессийн үед сэтгэл зүйгээ хянах оновчтой шийдвэр гаргах чадвартай болно | | | | /v/ | Эмнэлзүйн сургагч багш нар | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 2.Гардан үйлдлийн ур чадвар сайжруулах | | | | | | | | | | |
| 2.1 | Амилуулах яаралтай тусламж үзүүлэх сургалт | Танхим болон дадлага | Амь тэнссэн үед амилуулах суурь тусламжийг мэргэжлийн түвшинд үзүүлэх ур чадвартай болно | /v/ | | /v/ | | ЯТН, Сувилахуйн алба | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 2.2 | MNS 4621:2008 Тусламж үйлдлийн стандарт | Сургалт үнэлгээ | Сувилагч стандартын дагуу тусламж үйлчилгээ үзүүлэх чадвар сайжирна | /v/ | /v/ | /v/ | /v/ | Ахлах сувилагч нар | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 2.3 | Боолтын сувилагчийн ур чадварыг сайжруулах сургалт | Дадлага сургалт | Боолтын сувилагч нарын ур чадвар сайжирна | | | /v/ | /v/ | Сургагч багш нар | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 3.Харилцааны ур чадварыг сайжруулах | | | | | | | | | | |
| 3.1 | Ёс зүй харьцаа хандлагын тухай журам танилцуулах | Танхимын сургалт | Сувилагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг баримтлан харилцдаг болно | /v/ | | /v/ | | Ёс зүйн хороо | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 3.2 | Багаар ажиллах харилцааны сургалт | Бүлгээр дадлага сургалт | Багийн гишүүний үүргээ ухамсарлан харилцаа сайжирна | | | /v/ | /v/ | Гадны сургагч багш нараас сургалт авах | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 3.3 | Өвчтөн ар гэрийнхэнтэй харилцах чадварт суралцах | Тохиолдол, кейс, хэлэлцүүлэг | Өвчтөн түүний ар гэртэй үр дүнтэй итгэлцэлтэй харилцаа тогтоох чадвартай болно | | | /v/ | /v/ | Гадны сургагч багш нараас сургалт авах | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 4. Мэдлэг ур чадварын сургалтын үр дүнг тооцох | | | | | | | | | | |
| 4.1 | Ур чадварын үнэлгээг тооцох | Тест, гардан ажилбар | Сувилагчийн ур чадвар, сэтгэн бодох шийдвэр гаргах, харилцааны түвшин тодорхойлогдоно | | | | /v/ | Сувилахуйн албаны арга зүйч нар, эмнэлзүйн сургагч багш нар | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |
| 4.2 | Сургалтын үр дүнг хэлэлцэх, танилцуулах мэдээлэл хийх | Нэгдсэн мэдээлэл тайлагнах | Өмнөх түвшинтэй харьцуулсан үзүүлэлт дүгнэгдэнэ | | | | /v/ | Сувилахуйн албаны арга зүйч нар, эмнэлзүйн сургагч багш нар | Сувилахуйн албаны удирдлага | Нийт сувилагч нар |

| | |
|---|---|
| | хөнгөвчлөх зориулалтаар цэвэрлэгээний ус авах, бохир ус зайлуулах тусгай буланг байгуулсан байна.Засвар үйлчилгээтэй холбогдуулан тухайн тасгийн бүх орыг шинээр сольж, өрөө тус бүрийг ариун цэврийн өрөөтэй болгосон бөгөөд хэвтрийн болон асаргаа сувилгаа шаардлагатай үйлчлүүлэгчдэд зориулсан асаргааны өрөөг нэмж тоноглон засварлажээ.Түүнчлэн нийтийн эзэмшлийн талбай буюу коридорт эрчим хүчний хэмнэлт бүхий гурван шатлалт гэрлийн унтраалга, галын дохиоллын систем, аваарын гарц, төмөр дүүжин тааз хийснээр эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарт шаардлагад нийцсэн тохилог орчинд үзүүлэх бүрэн боломжтой болж байгаа юм.<br>    |
| *Хавсралт 3.7* | ЭМНЭЛГИЙН ОРЧНЫ ХАЛДВАРЫН ТАРХАХ НӨХЦӨЛИЙГ БУУРУУЛЖ БАРИЛГЫН АГААРЖУУЛАЛТЫГ САЙЖРУУЛЛАА.<br>Эмнэлгийн орчны халдварын тархах нөхцөлийг бууруулж барилгын агааржуулалтыг сайжруулах үүднээс төвийн хэмжээнд төлөвлөгөөт хагалгааны мэс заслын блокийн 5 өрөөний агааржуулалтын системийг зургийн даалгаврын дагуу бүрэн шинэчлэн засварласан байна. Мөн ажилчдын өрөө тасалгаанд хана, таазны нийт 13 ширхэг эйр кондейшнийг суурилуулж агааржуулалтыг сайжруулсан.<br> |

| | |
|---|---|
| |     |
| *Хавсралт 4.1* | АЖИЛТНУУДЫН ХАРИЛЦАА ХАНДЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ САЙЖРУУЛАХ СУРГАЛТЫГ ҮЕ ШАТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.<br>Төвийн нийт ажилчдад харилцаа хандлага, үйлчилгээний соёлыг сайжруулах үүднээс удирдлагын манлайлал, хувь хүний хөгжил, байгууллагын соёл, ёс зүйтэй харилцаа зэрэг нийт 21 удаагийн сургалтаар 1165 эмч эмнэлгийн мэргэжилтэнг сургалтад хамруулсан байна.<br>   |

<table>
<tr>
<td></td>
<td>




</td>
</tr>
<tr>
<td>Хавсралт 4.2</td>
<td>
ТӨВИЙН ХЭМЖЭЭНД УДИРДАХ АЖИЛТНЫ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.<br>
“Удирдах ажилтны сургалт”-нд тасаг нэгжийн удирдлага,дунд шатны менежерүүд болох нийт 84 эмч эмнэлгийн мэргэжилтэн баримжаа олгох 8 цагийн сургалтад хамрагдсан байна. Энэхүү сургалтаар “Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тайлан боловсруулах арга зүй”, гүйцэтгэлийн удирдлагын үр дүн, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал, “Удирдах ажилтны манлайлал байгууллагын соёл, төрийн албаны бичиг хэргийн стандарт зэрэг зайлшгүй шаардлагатай мэдээлэл,зааварчилгаа,зөвлөмжийг хүргэсэн.




</td>
</tr>
<tr>
<td>Хавсралт 4.5</td>
<td>
ҮНДЭСНИЙ МОНГОЛ БИЧГИЙГ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТӨД НЭВТРҮҮЛЛЭЭ.<br>
Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хүрээнд Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дэд захирлууд болон дунд шатны менежер 52 албан хаагч Монгол бичгийн дунд, гүнзгий шатны сургалтад хамрагдсан.
</td>
</tr>
</table>

| | |
|---|---|
| | Мөн архивын ерөнхий газрын 2025.01.09-ны өдрийн 06/30 дугаар албан бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS 6395:2022 стандартад нийцүүлэн хэвлэмэл хуудасны эх загварыг хянан баталгаажуулсан. Батлагдсан хэвлэмэл хуудсыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>    |
| *Хавсралт 5.2* | ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН 27-Р ОЛОН УЛСЫН ЭРДМИЙН ЧУУЛГАНЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.<br>Гэмтэл согог судлалын жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Олон улсын 27-р эрдмийн чуулганыг 2025 оны 10 сарын 03-ны “Эх орондоо оношлъё, эмчилье” уриан дор МГСЭМХ, ГССҮТөв хамтран амжилттай зохион байгууллаа.<br>Энэхүү чуулганд БНСУ, Энэтхэг, Герман, Япон, Тайван, Тайланд зэрэг орны эрдэмтэн, профессор, судлаачид болон Улаанбаатар хот болон орон нутгийн 180 гаруй гэмтэл согог судлалын эмч, мэргэжилтэн, судлаачид оролцов.<br>Энэ жилийн хуралд гадаадын зочин профессорын 8 илтгэл, дотоодын эмч, судлаачдын 18 илтгэл, ханын 25 илтгэл хэлцэгдлээ. Судлаачдын нийт 76 илтгэлээс бүрдсэн хурлын илтгэлийн хураангуй хэвлэгдэн гарлаа.<br>   |
| *Хавсралт 7.1* | ТАНДАЛТЫН ЦАХИМ САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТЭД ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙЛЭЭ.<br>Осол гэмтлийн тандалтын мэдээллийн бүртгэл, чанар, үнэн зөв, бүрэн байдлыг үнэлж анхан шатны эх сурвалжтай тулган шалгах, мэдээлэл дамжуулах үйл явц болон мэдээлэл хариуцсан ажилтнуудын мэдлэг, арга зүй, хандлагыг тодорхойлох зорилгоор |

| | |
|---|---|
| | ТТАХНЭ, БГДЭМТ, ЦТЭ, СХДЭМТ, ЭХЭМҮТ, ШШЕГ байгууллагуудад хяналт, үнэлгээний ажлыг зохион байгуулсан ба хяналт үнэлгээний тайлан, зөвлөмжийг нэгтгэн холбогдох байгууллагуудад илгээв.<br>    |
| *Хавсралт 7.2* | СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ СУРАЛЦАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.<br>Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих зорилгоор нийслэлийн ерөнхий боловсролын 9 сургууль , 4 цэцэрлэгийн нийт 1017 сурагч, багш, ажилтан албан хаагч,хүүхдүүдэд дараах сэдвээр  сургалт, сурталчилгаа,нөлөөллийн ажлыг  зохион байгууллаа<br>     |

| | |
|---|---|
| |    |
| *Хавсралт 7.3* | АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ҮГЭЭ ХЭЛЦГЭЭЕ АЯН-”НЫ ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА.<br>2025 оны 6-р сарын 01-нд 07 цагаас 18 цаг хүртэл Жанжин Д.Сүхбаатарын талбайд ГССҮТ-ийн нийт 9 эмч, эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр тусламж үйлчилгээг хүргэж ажилласан. НИЙТ: **450** хүнд үзлэг, оношилгоо хийж, мэдээлэл зөвлөмж хүргэсэн.<br>    |
| *Хавсралт 7.4* | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДУНД АНГИЙН СУРАГЧДАД ОСОЛ ГЭМТЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЗӨВ ДАДАЛ ХЭВШҮҮЛЭХ ПРАКТИК СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.<br>СҮҮ ХК-тай хамтран ЕБС-ын 8-10-р ангийн нийт **500** сурагчдад осол гэмтэл, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх практик сургалтыг амжилттай зохион байгуулсан. |

| | |
|---|---|
| |       |

*Эх сурвалж.    ГССҮТ-ийн Эдийн засаг маркетинг төлөвлөлтийн алба*
*Утас 77117444*